

## СЭТГҮҮЛ ЗҮЙН БОЛОВСРОЛД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ, ЧИГ ХАНДЛАГА

Д.Дагиймаа\*

\* ХИС-ийн Сэтгүүл зүй, медиатехнологийн тэнхимийн багш, доктор, профессор

**Түлхүүр үг:** сэтгүүлч, дээд боловсрол, оюутнууд, сорилт, мэргэжлийн үнэлэмж

Сэтгүүл зүйгээр суралцаж буй оюутнуудын дунд төгсөөд мэргэжлээрээ ажиллах сонирхол буурах хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон юм. Энэ нь сурах явцдаа мэргэжлээ солих, төгсөөд өөр чиглэлээр суралцах, мэргэжлээрээ ажиллахгүй байх зэргээр илэрч байгаа юм. Гэтэл технологийн нөлөөн дор ажлын байрт өөрчлөлт орж уламжлалт мэдээллийн хэрэгслээс гадна сэтгүүлч мэргэжилтэй боловсон хүчний ажиллах талбарууд нэмэгдсэнээр энэ мэргэжлийн эрэлт өндөр болсон. Тухайлбал, байгууллагын олон нийттэй харилцах алба, контент маркетинг, олон нийтийн сүлжээний хөгжүүлэлт чиглэлд сэтгүүлчид хөрвөж ажиллах болсон юм. Ийнхүү сэтгүүлч мэргэжлийн ажилтны эрэлт нэмэгдсэнээр ажил олгогчид ажилтанд тавигдах шаардлагаа сулруулж, ажлын туршлагагүй төгсөгчдийн дотоод ур чадварыг нь чухалчилж, өөрсдөө сургаж авах тактик баримталж байна. Дээрх нөхцөл байдал нийгэм дэх сэтгүүлч мэргэжлийн үнэлэмж, сэтгүүл зүйн боловсролыг эргэн харах шалтгаан болсон юм.

Сэтгүүл зүйн нөхцөл байдлын тухай ерөнхий үнэлэмж, сэтгүүл зүйн

ирээдүйд итгэх итгэл, хэвлэл мэдээллийн салбарын өөрчлөлтийн тухай ойлголт, байр суурийг дотоод талаас нь буюу сэтгүүлч мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудаар тодорхойлуулах зорилгоор социологийн судалгааг хийсэн юм. Судалгааг 8 их, дээд сургуулийн 235 оюутнаас онлайнаар 2020 оны 5 дугаар сард авсан.

Тэд өөрсдийн хүсэл сонирхлын дагуу (83,8%) элсэн ордог ч дийлэнх буюу 68 хувийнх нь мэргэжлийн талаарх ойлголт суралцах явцад нь өөрчлөгддөг байна. Оюутнууд сэтгүүлч мэргэжлийг сонирхолтой, бүтээлч, үргэлж шинийг эрэлхийлдэг, олон хүмүүстэй харилцдаг мэргэжил учраас 117 (50%), сэтгүүл зүйгээр дамжуулан нийгэмд бодит өөрчлөлт хийх зорилгоор 73 (31.2%), олонд нэр хүндтэй уран бүтээлч болох зорилгоор 65 (27,6%), үйл явдлын цэгт очиж сурвалжилга хийх зорилгоор 53(22.6%) сонгосон байна.

Оюутнуудын 82,1% нь сэтгүүл зүйн салбарт дунд гэсэн үнэлгээг өгч байна. Дунд болон муу гэж үзсэн 203(86,8%) оюутан шалтгаанаа сэтгүүлч олон нийтэд үйлчлэх эрх ашгаа умартаж ашиг орлогоо дээгүүрт тавьсан (51,7%), үзэл бодлоо тулгасан, тэнцвэргүй, мушгин гуйвуулсан мэдээлэл түгээдэг буюу ёс зүйгүй (43,2%) гэжээ. “Сургуулиа төгсөөд мэргэжлээрээ ажил-


лах уу” гэсэн асуултад 58,7 хувь нь тийм гэж хариулсан бол 37,4 хувь нь хараахан шийдээгүй, 3,8 хувь нь үгүй гэж хариулсан байна. Харин сэтгүүлчийн ангийн оюутнуудын дийлэнх буюу 48 хувь нь телевиз, 17,9 хувь нь байгууллагын олон нийттэй харилцах албанд, 13,1 хувь нь сайтад, 11,8 хувь нь тогтмол хэвлэлд, 1,7 хувь нь радиод 7,4 хувь нь бусад салбарт ажиллана гэж хариулсан байна. Энэ дүнгээс харвал оюутнуудын телевизэд ажиллах сонирхол буураагүй хэвээр байна. Монголын хэвлэл мэдээллийн зах зээлээ харвал нийт ажиллагсдын 50 гаруй хувь нь

телевизийн салбарт ажилладаг. (МХХ, 2020)

Сэтгүүлч мэргэжлээр төгсөгчид хэвлэл мэдээллийн байгууллагад хэдэн жил ажиллаж туршлага хуримтлуулж, эх сурвалжийн сүлжээтэй болсны дараа байгууллагуудын олон нийттэй харилцах албанд ажилладаг. Энэ нь цалин илүү, ажлын цаг тогтмол байдагтай холбоотой юм. Ийм учраас сэтгүүл зүйн сургуулиуд Харилцааны стратеги, ПиАр мэргэжлээр сургаж болох юм. Суралцагчдын судалгаа ч үүнийг мөн харуулж байна.

Хэрвээ тийм гэж хариулсан бол ХМХ-ийн аль салбарт ажиллах вэ?

229 responses




Зураг №1. Оюутнуудын төгсөөд ажиллах салбар.

Эх сурвалж: “Сэтгүүлч мэргэжлийн үнэлэмж” социологийн судалгаа. ХИС. 2020.

Харин төгсөөд сэтгүүл зүйн салбарт ажиллахгүй гэж хариулсан 114 оюутан ажиллахгүй шалтгаанаа өөд мэргэжлээр дахин суралцана (34,2%), цалин бага (26,3%), ажлын цаг их (15,8%),

нийгэмд үнэлэмжгүй гэж (13,2%), сонирхсон мэргэжил биш байсан (10,5%), ирээдүйгүй мэргэжил гэж үзсэн (0,9%), бусад гэж (23,5%) хариулсан байна.



Зураг №2. Оюутнуудын мэргэжлээрээ ажиллахаас татгалзах шалтгаан.

Эх сурвалж: “Сэтгүүлч мэргэжлийн үнэлэмж” социологийн судалгаа. ХИС. 2020.

Дээрх социологийн судалгааны дүнгээс үзвэл, мэргэжлээ өөдрөгөөр хардаг ч гэсэн салбартаа шүүмжлэлтэй хандаж оюутнуудын 40 орчим хувь нь сэтгүүл зүйн салбарыг хөдөлмөрийн нөхцөл муу гэж үнэлэн өөр мэргэжлээр суралцах сонирхолтой байна. Энэ судалгааг Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс 2019 онд Улаанбаатар хот болон 19 аймгийн 260 хэвлэл мэдээллийн хэрэгслийн 1100 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдыг хамруулан хийсэн хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөл байдлын талаарх судалгаатай харьцуулан үзэхэд оюутнуудыг ойлголт бодит байдлаас хол зөрөөгүй байна.

Ажиллагсдын дийлэнхийг 26-35 насны залуус эзэлдэг энэ салбарын өрхийн дундаж орлого улсын дунджаас доогуур байна. Сэтгүүлчдийн гэр бүлийн 77%-ийн өрхийн орлого хүрэлцдэггүй аж. ҮСХ-ноос 2019 оны 1-р улиралд ажиллагсдын сарын дундаж цалин 990 мянган төгрөг (татварын дараах) гэж тогтоосон бол хэвлэл мэдээллийн салбарынх 664 мянган төгрөг байна. Ажиллагсдын 92% нь өндөр боловсролтой ч улсын дунджаас 30 гаруй хувь доогуур цалин авдаг юм байна. Сэтгэл ханамжийн байдлын хувьд хамт олны уур амьсгалдаа хамгийн өндөр сэтгэл ханамжтай харин цалиндаа хамгийн сэтгэл ханамж муутай байна. Ажиллагсдын 60 орчим хувь нь цалин бага, цалингаа өгдөггүй, өсөх ирээдүй муутай, хамт олон даргатай зөрчилтэй гэсэн шалтгаанаар 1-4 удаа ажлаа сольсон тогтвор суурьшил муутай ажилладаг байна. Ажиллагсдын 76% нь өөрийгөө хөгжүүлэх, сургалтад суух хүсэлтэй ч санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг (49%) аж.

Ажлын цагийн хувьд салбарын ажиллагсад өдөрт дунджаар 9.1 цаг 7 хоногийн 6.5 өдөрт ажилладаг. Долоо хоногийн 7 өдрийн зөвхөн хагас өдрийг нь гэр бүлтэйгээ өнгөрөөх боломжтой, хэвлэл мэдээллийн салбар гэл бүлд ээлтэй бус салбар юм байна. Салбарын ажиллагсдын талаас илүү хувь нь нийтээр амрах өдрүүдээр ажилласан бол нөхөн амарч чаддаггүй (62%), цалингаа нөхөн авч чаддаггүй (60%), мөн ээлжийн амралтаа эдэлж чаддаггүй, эдэлж үзээгүй ч ажиллагсад олон байна<sup>1</sup>.

**С**этгүүл зүйн боловсрол. Дэлхий нийтэд их, дээд сургуульд элсэгчдийн тоо буурсныг их сургуулийн захирлаар ажиллаж байсан Michael T. Nietzel Форбест бичжээ. Сэтгүүл зүйн салбар ч үүнээс тойрсонгүй харин ч амаргүй 10 жилийг туулсан юм. Судалгаанаас үзвэл сэтгүүл зүй, олон нийтийн мэдээлэл харилцааны бакалаврын хөтөлбөрт хамрагдах оюутнууд 2010-2013 онд АНУ-д гурван хувиар буурсан байна. Тухайлбал, Бакалаврын түвшинд, элсэлт 2012 оноос 1.0 хувиар буурсан бол магистрын хөтөлбөрт хамрагдах түвшин 1.2 хувь, докторын элсэлт 7.1 хувь буурчээ. 2013 онд идэвхтэй ажиллаж байсан сэтгүүл зүй, олон нийтийн мэдээллийн хөтөлбөрүүдийн тоо таваар буурч 480 болжээ. Харин 2013 оныг өмнөх оныхтой харьцуулахад Олон нийттэй харилцах, зар сурталчилгааны чиглэлээр оюутнуудын хувь бараг өөрчлөгдөөгүй байна<sup>2</sup>.

Дараагийн жилүүдэд сэтгүүл зүйн хөтөлбөрүүдэд улам бүр хүнд цохилт ирсэн. Техасын Технологийн Их Сургуулийн 2017 онд гаргасан судалгаагаар 2013-2015 оны хооронд улсын хэмжээнд энэ чиглэлээрх бакалаврын

элсэлт 16.3 хувиар буурчээ. Ийнхүү сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны чиглэлээр оюутны сонирхол буурч байна. 1990-ээд оны эхэн үед үндэсний хэмжээнд бакалаврын түвшний элсэлт буурсан нь эдийн засаг суларсантай холбоотой. Энэ удаад эдийн засаг сэргэлтэд байснаараа ялгаатай. Харин Олон нийттэй харилцах мэргэжлийн бакалаврын элсэлт 2013 оноос хойш тодорхой хэмжээгээр өссөн байна<sup>3</sup>.

Сэтгүүл зүйн хөтөлбөрийн элсэгчдийн бууралт зөвхөн Америк гэлтгүй бусад улс орнуудад ч ажиглагдаж байна. Тухайлбал, Шинэ Зеландын сэтгүүл зүйн ангийн оюутны тоо 2013 оноос буурч, төгсөгчид мультимедиа чадвартай байх ёстой гэсэн салбарын хүлээлтийг өсгөх ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна<sup>4</sup>.

Сэтгүүл зүйн боловсролын түүхийг сөхөж үзвэл дэлхий дахинд сэтгүүл зүйн сургуулиуд XIX-XX зууны зааг дээр сонин хэвлэлийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор дэлхийн тэргүүний орнуудад байгуулагдаж эхэлжээ. Тийм сургуулийн тоо XX зууны эхний арван жилд хэдэн зуугаар тоологдох болжээ. Сэтгүүл зүй мандан бадарч байсан 1970-аад онд “Си Би Эс” телевизийн оройн мэдээний хөтөлөгч Уолтер Кронкайт олон нийтийн санал асуулгад Америкийн хамгийн итгэлтэй хүнээр шалгарч, “Нью-Йорк Таймс” сонин Пентагоны бичиг баримтуудыг дэлгэж, “Вашингтон Пост” сонин Уотергейтийн хэргийг илчилж байсан билээ. Тэр үед сэтгүүл зүйн сургуульд элсэгчдийн тоо ч суга өссөн байдаг<sup>5</sup>. Монголын тухайд ч 1970, 1980-аад онд хамгийн нэр хүнд, эрх ямбатай мэргэжил байж, нэвтрүүлэгч хүн АИХ-ын депутатаар сонгогдож, сэтгүүлчид Улс Төрийн Товчооны гишүүдтэй хаяа залган зусаж, сэтгүүл-

чийн ангид нийгмийн элит давхаргын хүүхдүүд суралцдаг байлаа.

**Д**элхий нийтийн боловсролын чиг хандлага 1990 оноос өмнө элитийн боловсролын үе ба цөөн элсэгчтэй, чанартай цөөн хөтөлбөртэй байсан бол 1990 оноос хойш дээд боловсрол нь бүх нийтийн боловсролын чиг хандлагад шилжиж их, дээд сургуулийн тоо олширсон юм. Монгол улсын хувьд 1991 онд улсын 14 их, дээд сургууль байсан бол хувийн сургуулиуд бий болж 2006 онд 180 их, дээд сургуулиуд Монголд үйл ажиллагаа явуулж байлаа. Харин 1990 онд 1 их сургууль сэтгүүл зүйн боловсрол олгож байсан бол 2006 онд 22 болж энэ тоо нэмэгдсэн юм. Харин өнөөдрийн байдлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 94 их дээд сургуулиас 14 их, дээд сургууль болон Хэвлэлийн хүрээлэн болон бусад төрийн бус байгууллага сэтгүүл зүйн чиглэлээр сургалт явуулж байна. Ийнхүү сургуулийн тоо цөөрч, түүнд суралцаж байгаа оюутны тоо ч мөн буурсан байна. 2019 онд 1749 оюутан 19 их дээд сургуульд суралцаж, жилдээ 400 гаруй оюутан төгсдөг байсан бол өнөөдөр суралцагчдын тоо 41.4 хувиар буурч 14 их, дээд сургуульд 1015 оюутан суралцаж байна. Энэ нь 2019 онд ЕБС-ийн элсэгчдийн тоо бага байсантай холбоотой хэмээн тайлбарлаж их том өөрчлөлт биш гэж ойлгож болох ч хандлагыг нь анхаарахгүй байж болохгүй юм.

Сургууль	2016	2019	Зөрүү
МУИС	215	180	-35
ХИС	116	172	+56
МУБИС	230	226	+4

РТМУС	323	218	-105
Отгонтэнгэр ИС	105	29	-74
Идэр Их Сургууль	55	29	-26
Зохиомж ДС	188	8	-180
Кино урлагийн ДС	82	20	-62
Улаанбаатар эрдэм ИС	48	8	-40
Их засаг их сургууль	61	50	-11
Сэтгүүлч коллеж/ Сити ДС	82	5	-77
Утга зохиол, нийгмийн ажилтны ДС	30	5	-25
МИУ	-	30	+30
МУИС	-	35	+35
Улаанбаатар дээд сургууль	44	-	-44
ХИС-ийн Дархан салбар сургууль	30	-	-30
Орхон ИС	17	-	-17
Соёл эрдэм ДС	40	-	-40
Олон улс судлалын ДС	24	-	-24
Их Монгол ДС	59	-	-59
<b>Total</b>	<b>1749</b>	<b>1015</b>	<b>724</b>

*Хүснэгт №1. Сэтгүүл зүйн сургуульд суралцагчдын тоо, 2020.*

*Эх сурвалж: Их, дээд сургуулиудын Сэтгүүл зүйн тэнхим.*

Дээрх хүснэгтээс харахад МУИС, ХИС, МУБИС, РМТУС гэсэн төрийн өмчийн 3 сургууль, төрийн бус өмчийн нэг сургуульд элсэгчдийн тоо нэмэгдэж бусад нь буурчээ. Үүнийг томоохон их сургуулиуд БМИҮЗ-д

хүргүүлсэн тайландаа, “манай хөтөлбөрөөр суралцагсдын элсэлтийн дундаж оноо жил бүр 500-гаас их, элсэгчдийн тоо жил ирэх бүр өсөж байгаа нь манай хөтөлбөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ өндөр, нийгэмд хэрэгцээтэй, ажлын байраар хангагдах магадлал өндөртэй, сонирхол татаж байгаа мэргэжил гэдэг нь харагдаж байна” хэмээн дүгнэсэн нь өрөөсгөл юм. Харин үүнд нөлөөлсөн хамгийн том хүчин зүйл бол 2016-2017 оны хичээлийн жилээс элсэгчдийн хяналтын тоог тухайн сургуулийн удирдах зөвлөлийн шийдвэрээр тогтоодог болсноор төрийн өмчийн болон хувийн нэр хүнд бүхий томоохон сургуулиудын элсэгчдийн тоо нэмэгдэж нөгөө талд төрийн бус өмчийн сургуулийн хувьд элсэгчийн тоо огцом буурчээ.

Судлаач М.Зулькафиль, хэдийгээр олон сургууль байгаа нь өрсөлдөөн бий болгох, асуудалд олон ургальч үзлийн үүднээс хандах сайн талтай боловч 18 сургуульд сэтгүүлч бэлтгэж байгаа нь манай орны хувьд ахадсан тоо юм. Ер нь чанартай 5-6 сургууль сэтгүүлч бэлтгэхэд хангалттай гэж үзэж байна<sup>6</sup> хэмээн судалгааны бүтээлдээ онцлон тэмдэглэж байв. Өнөөгийн элсэгчдийн хандлагаас харвал энэ нь биеллээ олох түвшин рүү дөхөж байна.

**С**этгүүл зүй дэх зарим ажлын байр үгүй болж байна. Оюутны тоо буурч байгаагийн томоохон шалтгаан нь уламжлалт сэтгүүл зүйн салбарын уналт гэж сэтгүүл зүй судлаачид үзэж байгаа билээ. Дэлхийн улс орнуудад дижитал шилжилт өрнөж, Монгол улсын хэвлэл мэдээллийн салбарт ч цахим шилжилт эрчимтэй явагдаж байна. 2019 оны эхний байдлаар 154 мэдээллийн сайт цаг үеийн мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэж байгаагаас 20 нь орон нутагт ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн байгуулла-

гууд олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглаж, өөрийн контентыг түгээх, сурталчлах, хэрэглэгчидтэй харилцах нь түгээмэл болж байна. Тухайлбал, телевизүүдийн 85 хувь нь албан ёсны фэйсбүүк хуудсаараа нэвтрүүлэг дамжуулж, үзэгчдийн санал, сэтгэгдлийг хүлээн авч байна. Түүнчлэн, 2019 онд цахимаар сонсох боломжтой радиогийн тоо гурваар нэмэгдсэн бол веб сайтаар нь дамжуулан нэвтрүүлгийг нь хүлээн авах боломжтой 23 телевиз байна. Ийнхүү бүх мэдээлэл интернэтэд тавигдаж, бүгд гар утаснаасаа мэдээлэл авч, ингэснээр хэрэглэгчид мэдээллийг үнэгүй авдаг зуршилтай болж, сэтгүүл зүйд итгэгчдийн тоо буурснаар хэвлэлийнхнийг сорьсон их өрсөлдөөн бий болсон.

АНУ-д насанд хүрэгчдийн 68 орчим хувь нь мэдээг сошиал медиа платформиос авдаг бөгөөд эдгээрийн дийлэнх нь фэйсбүүкийг анхдагч эх сурвалж гэж үздэг. Фэйсбүүкийн үнэлгээ одоо 470 тэрбум доллараас дээш байна. Гүүглийн зах зээлийн үнэлгээ 2012 онд 200 тэрбум доллараас бараг 800 тэрбум доллар болж өсчээ. “Гүүгл”, “Фэйсбүүк” хоёр дижитал зар сурталчилгааны зах зээлд ноёрхож байна. “MMCG” судалгааны байгууллагын судалгаагаар Монголчуудын 2019 оны хувьд 81 хувь нь фэйсбүүк хэрэглэж, 45 хувь нь фэйсбүүкийг, 61 хувь нь телевизийг мэдээллийн чухал эх сурвалжаар нэрлэж байна.

ХМХ	1880-аад оны сүүлч	2002	2012	2015	2018
Сонин	37	175	135	101	92
Сэтгүүл	32	48	99	86	78
Телевиз	1	32	132	131	128
Радио	1	37	84	69	50
Мэдээллийн сайт	-	-	68	98	109
БҮГД	71	292	518	485	457

Хүснэгт №2. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо.

Эх сурвалж: “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр” тайлан. МХХ. 2002-2019.

“Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр” тайлангаас үзэхэд, 2013 оноос хойш мэдээллийн хэрэгслийн тоо жил бүр буурч байсан бол 2018 онд 14-өөр, 2019 онд 45-аар нэмэгдэж 502 болсон байна. Энэхүү өсөлт нь гол төлөв мэдээллийн сайтын тоо олширсонтой холбоотой байв. Цаасан мэдээллийн хэрэгслийн тоо, тухайлбал сонины тоо буурсан хэвээр байгаа бөгөөд, 2019 онд сонины нэр төрөл

сүүлийн 20 жилийн туршид байгаагүйгээр цөөрч, сонины борлуулалт 5 хувиар, сэтгүүлийн борлуулалт 44 хувиар тус тус буурчээ.

Энэхүү шилжилттэй холбоотойгоор ажлын байранд ч мөн өөрчлөлт орж байна. Дэлхийн ихэнх хүмүүсийн хувьд ажил бол зөвхөн орлогын хэрэгсэл биш бөгөөд оршин тогтнох, өөрийгөө хүндэтгэх хэрэгцээ байдаг. Өнгөрсөн онд Францын сэтгүүлч Арнауд

Дубуст амиа хорлосон нь сэтгүүлчийн ажлын талаар эргэн бодоход хүргэсэн юм. Дубусын санхүүгийн бэрхшээл, ялангуяа сүүлийн 10 жилд түүнд хүндээр тусаж, сэтгэл хямралтай тулгарч байв. Сүүлийн 10 жилд сэтгүүл зүйн 100,000 ажлын байр алга болж, үлдсэн олон ажил нь бүрэн цагийн цалинтай ажил биш харин чөлөөт орон байр болж хувирав<sup>7</sup>. Үүний зэрэгцээ мэдээллийн хэрэгслийн сурталчилгааны орлого 30 тэрбум доллараар буурчээ. Энэ зар сурталчилгааны орлогын бууралт нь харагдахаасаа хамаагүй илүү утга учиртай юм. Сэтгүүл зүй дийлэнхдээ зар сурталчилгааны орлогоос санхүүждэг тул эрэн сурвалжлах сэтгүүл зүйг

санхүүжүүлэх, авлигыг устгах, корпорацийн зүй бус үйлдлийг илчлэх, хүчирхийллийг багасгахад зарцуулах мөнгө багасаж байна гэсэн үг юм.

АНУ-ын Хөдөлмөрийн товчооны статистик өгөгдөлд хийсэн “Pew research center”-ийн судалгаагаар 2008 оноос хойш сонины ажилтнууд тал хувь байхгүй болжээ. Гэхдээ 2014 оноос хойш бусад мэдээ үйлдвэрлэдэг салбарт, ялангуяа дижитал хэрэгслүүдэд ажлын байр нэмэгдсэн нь сонины энэ алдагдлыг нөхөж, сүүлийн таван жилийн хугацаанд АНУ-ын мэдээллийн салбарын нийт ажилчдын тогтвортой байдлыг хангаж чадсан юм.




График №3. Америкийн сэтгүүл зүйн ажлын байрны өөрчлөлт.  
Эх сурвалж: Pew research center.

2008-2019 онуудад АНУ дахь мэдээний өрөөний нийт ажил эрхлэлт 23%-иар буурсан гэж шинэ дүн шинжилгээнд дурджээ. 2008 онд сонин, радио, өргөн нэвтрүүлгийн телевиз, кабель болон "бусад мэдээллийн үйлчилгээ" гэсэн мэдээлэл үйлдвэрлэдэг таван салбарт 114,000 орчим мэдээллийн хэрэгслийн ажилтнууд, сурвалжлагч,

редактор, гэрэл зурагчин, зураглаач ажиллаж байв. Харин 2019 он гэхэд энэ тоо 88,000 болж буурч 27000 орчим ажлын байр алга болжээ. 2014-2019 он хүртэл ажилтнуудын тоо тогтворжиж 88000 орчим байна. Ажил эрхлэлтийн урт хугацааны бууралт сонинтой илүү хамаатай байв. Сонины ажилтнуудын тоо 2008-2019 оны хооронд 51%-иар

буурч 71,000 орчим ажилчдаас 35,000 болж буурчээ. Харин телевиз, радио, кабелийн болон дижитал хэрэгслүүдийн гэсэн бусад дөрвөн салбарт харьцангуй тогтвортой байсан төдийгүй 2014 оноос аажим өссөн хандлага байна.

2008 оноос хойш дижитал хэрэгслийн ажилтнуудын тоо 2,4 дахин нэмэгдэн байна. Телевиз, кабелийн телевизийнх харьцангуй тогтвортой байсан бол радиогийн салбар ажилтнуудынхаа

23%-ийг алдаж, 2008 онд 4,600 ажилчдаас 2019 онд 3500 болж буурсан байна. Хувиар нь харвал радио, сонин хамгийн их бууралттай байгаа салбар болж байна<sup>9</sup>. 2008 онд сонины ажилтнууд нийт хэвлэл мэдээллийн ажилчдын 62 хувийг бүрдүүлж байв. 2019 он гэхэд 40 хувь болж буурчээ. Үүний эсрэгээр телевизийн өргөн нэвтрүүлгийн ажилтнууд нийт ажилчдын дийлэнх хувийг эзэлж, харин дижитал хэрэгслийнх 3 дахин өсжээ.

2019 он байдлаар Монголын хэвлэл мэдээллийн салбарт Монголд хэвлэл мэдээллийн 430 орчим хэрэгсэл тогтмол үйл ажиллагаа явуулж, эдгээрт 4500 хүн ажиллаж байна. 2100 орчим бүтээлч ажилтнууд буюу сэтгүүлч, сурвалжлагч, редакторууд 670 удирдах албан тушаалтан байна. Энэ тоо 2009 оныхоос 660 хүнээр буюу 15 хувиар өсжээ.

Ийнхүү ажлын байрны өөрчлөлт нь сэтгүүлчээс шинэ ур чадварыг шаардах болсон юм. Дижитал эрин сэтгүүлчдэд аливаа сэдвийг олон нийтэд хүргэхдээ мэдээллийн их өгөгдөлд тулгуурлан асуудлын мөн чанарыг бүрэн гүйцэд зураглан гаргаж чадах мультимедиа болон, мэдээллийг олон форматаар түгээх конвергент сэтгүүл зүйн ур чадварыг шаардах болов.

Иймээс сэтгүүл зүйн салбарын өмнө тулгарч байгаа асуудал бол сургалтын хөтөлбөрөө эрс шинэчлэх, түүний дагуу мультимедиа лабораторитой болох. Гэхдээ бүхэл бүтэн сэтгүүл зүйн хөтөлбөрийг боловсруулж, эрс шинэчлэх нь хялбар ажил биш бөгөөд боловсролын хүнд суртлын хүрээнд сургалтын хөтөлбөрт хурдан өөрчлөлт оруулахад хэцүү байгаа тал ч бас бий. Харин орчин үеийн шаардлагад нийцүүлсэн лаборатори байгуулах нь өндөр зардалтай.

Зарим улс орны их, дээд сургууль зардал нэмэгдсэнээр засгийн газраасаа санхүүжилт хүсэж байгааг мэдэгдсэн.

Дүгнэлт. Ройтерс институтийн сэтгүүл зүйн ирээдүйн талаарх таван чиг хандлага, тэдгээрийн нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон шинэ тайланд дурдсанаар сэтгүүл зүй улам чухал боловч хүч багатай болж байна<sup>9</sup>. Түүнчлэн бэрхшээл тулгарсан ч гэсэн сэтгүүл зүй нь урьд өмнө байгаагүйгээр

«

**Сэтгүүл зүйн салбарын өмнө тулгарч байгаа асуудал бол сургалтын хөтөлбөрөө эрс шинэчлэх, түүний хүрээнд мультимедиа лабораторитой болох. Гэхдээ бүхэл бүтэн сэтгүүл зүйн хөтөлбөрийг боловсруулж, эрс шинэчлэх нь хялбар ажил биш бөгөөд боловсролын хүнд суртлын хүрээнд сургалтын хөтөлбөрт хурдан өөрчлөлт оруулахад хэцүү байгаа тал ч бас бий**

»



илүү сайн ажиллаж байгаа гэдгийг нотолж байна.

Харин сэтгүүл зүйн сургуулиуд хоёр талдаа бэрхшээлтэй тулгарч байна. Нэг талаараа дижитал хувьсгал уламжлалт мэдээллийн хэрэгслийг хүчээр шахаж байгаа тул оюутны тоо мэдэгдэхүйц буурч байна. Нөгөө талаар, ижил дижитал хувьсгал нь энэ салбар нь сэтгүүл зүйн сургуулиудад оюутнуудад өргөн хүрээний мульти-медиа ур чадварыг эзэмшүүлэхийг шаардаж байна. Энэ нь ихээхэн зардалтай бөгөөд эдгээр ихэр сорилт сэтгүүл зүйн сургуулиудыг хаалгыг барихад хүргэнэ. Үнэн хэрэгтээ Монголын сэтгүүл зүйн сургуулиуд хэт олон байсан бөгөөд өнөөг хүртэл хаагдсан нь эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэржүүлэлтийг харуулж байна.

Суралцагчид мэргэжлээрээ ажиллах сонирхол буурсан нь нийгэм дэх сэтгүүлч мэргэжлийн нэр хүнд унаж, цалин багатай, хүнд ажил гэж ойлгогдох болсон нь дараах нэг шалтгаан юм. Хэдийгээр ажлын байр хангалттай байгаа ч хөдөлмөрийн нөхцөлөөс хамаараад хамгийн тогтворгүй салбар болж байна.

**Д**ээрх бүхний гол шалтгаан бол дижитал хувьсгал бөгөөд конвергент сэтгүүл зүйн чиглэлээр мэргэшсэн ажилд авах эрэлт улам бүр нэмэгдэж байна. Эдгээр бэрхшээлийг даван туулж чадахгүй байгаа сэтгүүл зүйн зарим сургууль хаагдана. Орчин үеийн боловсролын чиг хандлага нь бие даан суралцах, нас, цаг хугацаанаас үл хамааран өөрийн мэдлэг, боловсролыг тасралтгүй хөгжүүлэх чиглэл рүү хандаж байна. Сэтгүүл зүйн сургуулиудын хувьд дараах боломжууд байна. Үүнд, онлайн сургалтаар зэрэг олгох, онлайн курс хичээл бий болгох, ажил олгогчдын хүсэж буй ур чадварыг олгохын тулд

шинэ хөтөлбөр нээх, сэтгүүлчээр ажиллаж байгаа хүмүүст гадаад хэлний болон мэргэжлийн ахисан шатны сургалт явуулах, хөтөлбөрөө эрэлт үүсэж байгаа харилцааны стратеги, ПиАр мэргэжил рүү чиглүүлэх гэх мэт.

Харин Монголын хэвлэл мэдээллийн салбарын өмнө сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөл байдал, хөдөлмөрлөх эрхийг хамгаалах нь тулгамдсан асуудал болж байна. Энэ өөрчлөлтийг шинэчлэх, туршлагажих, алдаа, сорилтоо баталж байж даван туулах юм.

### Эшлэл

- <sup>1</sup> МХХ. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан. 2019. ХБНГУ-ын Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. УБ.
- <sup>2</sup> Lee B. Becker, Tudor Vlad, Holly Simpson. 2013. Annual Survey of Journalism Mass Communication Enrollments: 2013 Annual Survey of Journalism Mass Communication Enrollments. Journalism & Mass Communication Educator. 2014.
- <sup>3</sup> Gotlieb, Melissa R.; McLaughlin, Bryan; Cummins, R. Glenn. 2015. Survey of Journalism and Mass Communication Enrollments: Challenges and Opportunities for a Changing and Diversifying Field. Journalism and Mass Communication Educator. 2017.
- <sup>4</sup> Hannis, Grant. Journalism Education in New Zealand: Its History, Current Challenges and Possible Futures. Asia Pacific Media Educator. 2017.
- <sup>5</sup> Оюунгэрэл А. Иргэний сэтгүүл зүй ба мэргэжлийн сэтгүүл зүй. // academia.edu. 2016.
- <sup>6</sup> Маулет, Зулькафиль. Сэтгүүлчийн мэргэжил. 2014. УБ.
- <sup>7</sup> Spencer, Keith A. How to save journalism. <https://www.salon.com/2019/06/09/how-to-save-journalism/>. 2019.

- <sup>8</sup> center, Pew research. U.S. newspapers have shed half of their newsroom employees since 2008. <https://www.pewresearch.org/fact-tank/2020/04/20/u-s-newsroom-employment-has-dropped-by-a-quarter-since-2008/>
- <sup>9</sup> Rasmus Kleis Nielsen, Meera Selva. More Important, But Less Robust? Five Things Everybody Needs to Know. 2019. Reuters institute. Oxford.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. center, Pew. research. (2019, April 20). U.S. newspapers have shed half of their newsroom employees since 2008. Retrieved from [pewresearch.org: https://www.pewresearch.org/fact-tank/2020/04/20/u-s-newsroom-employment-has-dropped-by-a-quarter-since-2008/](https://www.pewresearch.org/fact-tank/2020/04/20/u-s-newsroom-employment-has-dropped-by-a-quarter-since-2008/)
2. Gotlieb, M. R., McLaughlin, B., & Cummins, R. G. (2017). 2015 Survey of Journalism and Mass Communication Enrollments: Challenges and Opportunities for a Changing and Diversifying Field. Journalism and Mass Communication Educator.
3. Hannis, G. (2017). Journalism Education in New Zealand: Its History, Current Challenges and Possible Futures. Asia Pacific Media Educator.
4. Lee B. Becker, Tudor Vlad, Holly Simpson. (2014). 2013 Annual Survey of Journalism Mass Communication Enrollments: 2013 Annual Survey of Journalism Mass Communication Enrollments: Journalism & Mass Communication Educator.
5. Rasmus Kleis Nielsen, Meera Selva. (2019). More Important, But Less Robust? Five Things Everybody Needs to Know. Oxford: Reuters institute.
6. Spencer, K. A. (2019, June 9). Salon. Retrieved from [www.salon.com: https://www.salon.com/2019/06/09/how-to-save-journalism/](https://www.salon.com/2019/06/09/how-to-save-journalism/)
7. Маулет, З. (2014). Сэтгүүлчийн мэргэжил. Улаанбаатар: Удам соёл ХХК.
8. МХХ. (2019). Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан. Улаанбаатар: ХБНГУ-ын Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар.
9. МХХ. (2020). Монголын хэвлэл мэдээлэл -Өнөөдөр. Улаанбаатар: Монголын хэвлэлийн хүрээлэн.
10. Оюунгэрэл. А (2016). Иргэний сэтгүүл зүй ба мэргэжлийн сэтгүүл зүй. academia.edu.

#### **Summary**

Mongolian journalism education and working conditions for journalists: The study was conducted to find out the reasons why students studying journalism have lost interest in their profession in recent years. The main reason was the decline in the professional reputation of journalists as low-paid and hard work. Therefore, although there are enough jobs, it is the most unstable sector depending on working conditions. Journalism university, on the other hand, face challenges on both sides. Vocational journalism education in Mongolia is facing the twin challenges of declining student numbers and increasing industry expectations that graduates should have strong multimedia skills, there is a growing demand for graduates majoring in convergent journalism.